

БАТЛАВ. МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Дүн шинжилгээний ажлын нэр:

Хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн, гүйцэтгэл удааширсан шалтгаанд дүн шинжилгээ хийх

2. Дүн шинжилгээний ажлын код:

ҮАГ-ГАГ/2013/02-ДША

3. Дүн шинжилгээ хийх үндэслэл, бүрэн эрх:

“Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дугаар тогтоолоор өгөгдсөн үүрэг, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд энэхүү дүн шинжилгээний ажлыг хийнэ.

4. Дүн шинжилгээний ажлын зорилт:

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд “0.0” дүнтэй тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн, гүйцэтгэл удааширсан шалтгаан нөхцлийг нарийвчлан тогтоох, гүйцэтгэл, хэрэгжилтийн явц байдалд дүн шинжилгээ хийх, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан, дүнг УИХ-д танилцуулахад дүн шинжилгээний ажлын зорилт чиглэгдэнэ.

Дүн шинжилгээний ажлыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ.

Үүнд:

- Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд “0.0” дүнтэй тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг яагаад нэмэгдсэн бэ?
- Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд “0.0” дүнтэй тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл яагаад удааширсан бэ?

5. Хамрах хүрээ:

ДША нь ЭЗХЯ, Сангийн яаманд дээр төвлөрөх бөгөөд ХЗЯ, БХБЯ, БХЯ, БШУЯ, ЗТЯ, ССАЖЯ, ҮХААЯ, ХАХНХЯ, ЭМЯ, ОБЕГ зэрэг яам, агентлагууд төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч байгууллагууд хамрагдана.

6. Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад “0” дүнтэй тусгагдсан хөрөнгө оруулалтын ТАХ-г холбогдох байгууллага, хэрэгжсэн хугацаа, байршлаар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Захиалагч байгууллага: Сангийн яам 4, ХЗЯ 5, БХБЯ 24, БХЯ 1, БШУЯ 125, ЗТЯ 18, ССАЖЯ 39, ҮХААЯ 8, ХАХНХЯ 3, ЭМЯ 10, Шадар сайдын багцад буюу ОБЕГ-т 4 байна.
- Хугацааны хувьд: 2008 оноос 9, 2009 оноос 1, 2010 оноос 8, 2011 оноос 25, 2012 оноос 123, 2013 оноос 75 төсөл, арга хэмжээ тус тус хэрэгжиж эхэлсэн байна.
- Байршлын хувьд: Архангай 13, Баянхонгор 5, Булган 4, Баян-Өлгий 6, Говь-Алтай 5, Говьсүмбэр 1, Дархан-Уул 5, Дорноговь 6, Дорнод 16, Дундговь 11, Завхан 15, Орхон 6, Өвөрхангай 6, Өмнөговь 7, Төв 4, Сэлэнгэ 16, Сүхбаатар 9, Хэнтий 15, Ховд 16, Хөвсгөл 10, Увс 13, нийслэлд 52 байна.

7. Эрсдэлийн үнэлгээ:

Төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээ, ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “ДУНД” гэж үнэлсэн. (Хавсралт №1-д үзүүлэв)

8. Арга зүй:

ДША-ыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглахын зэрэгцээ захиалагч байгууллагуудын ТАХ-ний төлөвлөлтийн баримт материалд судалгаа хийх, хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, гүйцэтгэгч байгууллагын тайлан, ажлын гүйцэтгэлийн баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, хэрэглэгч, үйлчлүүлэгчийн орчинд судалгаа, нөхцөл байдлын шинжилгээ хийх, түүвэрчлэн шалгаж үр ашигт байдлыг үнэлэхийн зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу газар дээр нь очиж биет болон баримтат нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

9. Дүн шинжилгээ хийхэд ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн акт болон шаардлагатай бусад баримт бичиг, тухайн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гүйцэтгэх стандартын хэм хэмжээг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль,
- Монгол Улсын 2008-2013 оны төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Улсын Их Хурлын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дугаар тогтоол,
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт норм нормативууд.

10. Гүйцэтгэх хугацаа:

Төлөвлөлтийн үе шатны ажлыг 2013 оны 11 дүгээр сарын 18-наас, талбарын ажлыг 11 дүгээр сарын 25-наас, дүн шинжилгээ, тайлагналын үе шатны ажлыг 12 дугаар сарын 25-наас эхлэн тайланг 2014 оны 3 дугаар сарын 1-ний дотор дуусгана.

11. Багийн бүрэлдэхүүн:

ДША-ыг УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Б.Баттуяа удирдаж, Нэгдүгээр хэлтсийн захирал, менежер Г.Гүнжидмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ГАГ-ын I, II хэлтсийн аудитор, шинжээч нар газрын захирлын баталсан хуваарийн дагуу гүйцэтгэх ба шаардлагатай тохиолдолд АНАГ-ууд аудитын багт дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

ДША-д мэргэжлийн шинжээчдийн багийг гэрээгээр авч ажиллуулна.

12. Тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:

ДША-ын тайлан оршил хэсэг, ДША-ын дүн, дүгнэлт, холбогдох газрын санал, түүнд хийсэн тайлбар, зөвлөмж, хавсралт гэсэн агуулгаар үндсэн зорилтын дагуу бичигдэх бөгөөд тайлангийн төслийг УАГ-ын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

13. Шаардагдах хөрөнгө, нөөц:

А. Аудитор, шинжээч: 16 хүн – 150 хүн/өдөр

Б. Санхүүгийн нөөц: 35,000.0 мянган төгрөг

- Цалин – 34,700.0 мянган төгрөг
- Бичиг хэрэг – 300.0 мянган төгрөг

В. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, видео камер, зургийн аппарат болон бусад техник хэрэгсэл

Шинжээч ажиллуулах, орон нутагт томилолтоор ажиллах, зардлын төсвийг тусад нь боловсруулж батлуулна. (Хавсралт №5-д үзүүлэв)

Аудитын төлөвлөгөөг

Хянаж зөвшөөрсөн:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ


 Б.БАТБАЯР

Боловсруулсан:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ

 Б.БАТТУЯА
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ХЭЛТСИЙН ЗАХИРАЛ,
МЕНЕЖЕР

 Г.ГҮНЖИДМАА
АХЛАХ АУДИТОР

 Д.ЭРДЭНЭЧУЛУУН
Д.ЦЭРЭНДОРЖ
Д.БАТТУЛГА